ийн ХСУА, Хилийн сургууль, Онцгой байдлын сургуулиуд хичээлийн хөтөлбөртөө“Ерөнхий цэргийн тактик” хичээлийг оруулах шаардлагатай.

Түүнчлэн улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах зорилго бүхий хилийн инженерийн байгууламжийг сэргээн засварлах, шинээр бий болгох, хариуцсан хэсгийн газар зүйн онцлогт тохирсон шинэ техник. технологийг хил хамгаалалтад нэвтрүүлэх,ашиглагдаж байгаа техник технологи нь өнөөгийн хил хамгаалалтын бэлэн байдлыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй зэрэг учир дутагдалтай байгааг харгалзан үзэж шинэчлэлт хийх, хилийн манааны уналгыг газар оронд тохирсон туулах чадвар сайтай, эдийн засагт хэмнэлттэй техник хэрэгсэл нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хилийн отряд, заставын удирдлагьн бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл техник, сургалт бэлтгэл, албаны болон материаллаг техникийн хангалтын нөөц, бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл. албаны сахилга зохион байгуулалтыг бэхжүүлэх асуудал нь албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, үүссэн байдлын үед зохицон ажиллах чадвартай байхад чиглэгдэнэ гэж үзэж байна.

***Г.Даваатогтох*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, дэд хурандаа*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД “МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС хилийн ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр хил хамгаалах байгууллагын үндсэн үүргийг хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтын талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх зарим асуудлыг авч үзлээ.*

***Түлхүүр*** *үг: Хил хамгаалалт, хил хамгаалах байгууллага, төрөөс хилийн талаар баримтлах бодлого.*

Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нь хил хамгаалах байгууллага болон Монгол Улсын хувьд чухал асуудал юм.

Энэ чухал асуудлыг илүү боловсронгуй болгохын тулд “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг төрөөс баталж өгсөн.

Энэхүү бодлогын 5 дахь хэсэгт: ‘*Зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай болгож, хилийн боомт газарт ажиллах хяналтын албадын үйл ажиллагааг нь уялдуулан, нэгдсэн зохицуулалтад оруулах;" 31. дэх хэсэгт: «Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг

дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах;", 2 дахь хэсэг: “Хил хамгаалах албаны үйл ажиллагаанд улс төр, дипломат, тагнуул, инженер-техник, хяналтын болон дэглэм сахиулах зэрэг аргыг оновчтой ашиглах;”

Дархан хил хөтөлбөрийн 3.6 дахь хэсэг "Хилийн тагнуулын албыг бэхжүүлэх улсын хилийг гүйцэтгэх ажлын шугмаар хамгаалах ажиллагааг боловсронгүй болгох" гэсэн заалтын хэрэгжилтийг хангах, хилийн тагнуулын албыг 2015 онд батлагдсан Монгол Улсын "Тагнуулын тухай” хуулиар Тагнуулын ерөнхий газарт шилжүүлсэн нь энэхүү бодлогын баримт бичигтэй зөрчилдсөн байна. Гэхдээ хилийн тагнуулын албыг Монгол Улсын тагнуулын нэгдсэн ажиллагааг хангах үүднээснэгтгэсэн байхыг үгүйсгэж болохгүй юм. Ингээд дээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг доорх байдлаар судаллаа.

Зорчигч тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг шуурхай болгох чиглэлээр дараах ажлуудыг хийсэн.

1. 2014 оны 04 дүгээр сарын 01-нээс “Хилийн боомтын тухай хууль’-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

2. ОХУ-тай 2014 оны 07 дугаар сарын 01-нээс “Иргэд харилцан визгүй зорчих" Монгол улсын олон улсын гэрээг байгуулан хэрэгжүүлж эхэлсэн боловч боомтууд дээр ачаалал үүсч иргэд 3-24 цаг хүлээж боомтоор нэвтрэх болсон. Түүнчлэн Замын үүдийн боомтоор өнгөрөгч 2014 оны 04 сарын 01-ээс 2015 оны тухайн үе хүртэлх хугацаанд улсын хил нэвтэрсэн зорчигчдын тоо, БНХАУ-ын Эрээний боомтын зорчигчдын тооноос 100 гаруй мянган хүнээр зөрсөн[1], Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн автозамын боомтоор илрүүлээгүй алдсан зөрчлийн тоо дээрх хугацаанд 32 хувиар нэмэгдсэн байна.[*] [2]

Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах бодлого алдагдаж 2014 оны 04 дүгээр сарын 01-ээс “Хилийн боомтын тухай хууль” хэрэгжсэнээр хилийн шалган нэвтрүүлэх алба нь Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын мэдэлд очсон. “Тагнуулын тухай хууль” батлагдан мөрдөгдөж эхэлснээр хилийн тагнуулийн алба нь Тагнуулын ерөнхий газарт нэгдсэнээр энэхүү бодлого, хөтөлбөрийн зарим

[1]ХХЕГ.Хилийн боомтын хэлтсийн статистик мэдээ. 2015.
[2]*Хилийн ... дугаар анги.* Хил хамгаалалт, хилийн боомтын албаны статистик мэдээ. 2015.

заалтууд хэрэгжихэд хүндрэлтэй байдал үүсгэж төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсын олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх. Бидний үзэж байгаагаар Монгол улсын олон улсын гэрээг хэрэгжүүлж байна. Гэхдээ боомтоор илэрсэн зөрчлийг Хилийн төлөөлөгчийн шугамаар шийдвэрлэх тухай хилийн хэлэлцээрийн заалт зөрчигдөж байсан нь шинэчлэн батлагдсан “Хилийн тухай" хуулиар засагдсан. Улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байж, хилийн асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх. Улсын хилийн шугам тэмдэгийн байршил бол улс орны нутаг дэвсгэрийн аюулгүй байдалтой шууд холбоотой. Ялангуяа Монголчууд бид газар нутагтаа халдахыг тэвчиж байгаагүй ард түмэн юм. Энэ жишээг Хүннүгийн хаан Модун Шаньюугын жишээнээс харж болно.[1] Сүүлийн 10 жилийн хугацаанд хилийн шугам. тэмдэг холбоосыг зориудаар өөрчилсөн асуудал гараагүй боловч усан хилийн асуудал эргэлзээг төрүүлдэг. “МУ, ОХУ-ын Хилийн дэглэмийн гэрээ”-ний 32 дугаар зүйлд: “Улсын хилийн шугам голын үндсэн гольдролын дундуур өнгөрч байгаа голын гольдрол өөрчлөгдсөн тохиолдолд шинэ үндсэн гольдролын дундуур тооцно” гэж заасан байдаг. Улсын хил болж байгаа голын гольдрол өөрчлөгдөх нь энэхүү үндсэн үүргийг бүрэн биелүүлэхэд тулгарч байгаа гол бэрхшээл болж байна.

Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2010-2015 онд нийт 197 хилийн зөрчил гарсаны 41 буюу 20.8 хувийг 2010 онд, 39 буюу 19.7 хувийг 2011 онд. 31 буюу 15.7 хувийг 2012 онд, 30 буюу 15.2 хувийг 2013 онд, 29 буюу 14.7 хувийг 2014 онд, 27 буюу 13.7 хувийг 2015 онд илрүүлсэн байна. Нийт хилийн зөрчлийн 3.5 хувийг илрүүлж чадаагүй байна. Хил орчмын дэглэмийн зөрчил өнгөрөгч 6 жилд 163 удаа гарсаны 98.2 хувийг илрүүлэн шийдвэрлээд байна. Харин энэ хугацаанд нийт 11 удаагийн хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байна. Ажил дүгнэх журманд хилийн зөрчлийг илрүүлсэн талаар тусгасан боловч хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тусгасан.

Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үнэлэмжийг тодорхойлох асуудал одоо ч тодорхойгүй байна. Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь хилийн зөрчлийг илрүүлэхтэй ач холбогдолын

[1] *Ч.Далай.* Монголын түүх. - УБ„ 1998. 55 дах тал.

хувьд адилхан байх болов уу гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хил хамгаалах байгууллагын хэмжээнд зохион байгуулах талаар тодорхой баримт бичиг боловсруулан баталж мөрдөх.

Д. Шүүн таслах ажиллагаа болон хорих анги, цагдан хорих байрнаас оргон зайлж улсын хил нэвтрэхийг завдсан, эсхүл нэвтэрсэн яллагдагч, ялтны талаарх мэдээлэл, лавлагааг тахарын албанд гаргаж өгөх, хамтран ажиллах:

Энэ Өнгөрөгч 2015 онд Хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох хилийн тагнуулын албыг Тагнуулын ерөнхий газарт шилжүүлсэн. Шүүн таслах ажиллагаа болон хорих анги цагдан хорих байрнаас оргон зайлсан этгээдийн нэрсийг Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний байгууллагад холбогдох байгууллагаас ирүүлдэг бөгөөд энэ жагсаалтад нэр орсон этгээдийг улсын хил нэвтрэхийг завдах үед нь саатуулсан бол түүнийг Тагнуулын байгууллагад шилжүүдэг байна. Энэ ажиллагаанд Хил хамгаалах байгууллагын оролцоо бодит байдал дээр байхгүй болсон байна. Хил хамгаалах байгууллага. Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний байгууллагын эксперт болох тус бүр 10 албан хаагчаас судалгаа авахад[1] ИХШХБ-ын албан хаагчид - Саатуулах нэрсийн жагсаалтад орсон этгээдийг саатуулаад Тагнуулын байгууллагад хүлээлгэн өгдөг гэсэн бол ХХБ-ын албан хаагчдийн 6 нь энэ талаар мэдээлэлтэй байдаг бол 4 огт мэдэхгүй гэж хариулсан байна. ИХШХБ-ын албан хаагчдийн 4 нь ХХБ-ын нэгжид хэнийг саатуулсан талаар мэдээлэл өгдөггүй гэсэн бол ХХБ-ын албан хаагчдийн 5 нь ИХШХБ-аас хэнийг саатуулсан талаар мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хууль, олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Хил хамгаалах байгууллагын үндсэн үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох боломжтой гэж үзэж байна.

1. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор энэ хөтөлбөрийн биелэлтийг жил бүр улсын их хуралд тайлагнаж заалтыг хэрэгжүүлэх.

2. Хил хамгаалах байгууллагын нэгдмэл байдлыг хангах. Үүнд: "Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх н тухай хуулийг хэрэгжүүлэх баримт бичгүүдийг хуультай уялдуулан боловсруулах.

[1] *Алтанбулагын автозамын боомт.* экспертүүдээс авсан судалгаа. 2016 .

3. Усан хил болж байгаа голын үндсэн гольдролын өөрчлөлтийн талаар судалгааг хөтөлж баримтжуулан газрын гадаргуу дээрх усан хилийн эргийг бетондож, гольдрол өөрчлөгдөхгүй байх арга хэмжээг авах.

4. Хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг хилийн зөрчлийн илрүүлэлт, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан талаар хилийн застав, отряд нэгжүүдийн ажил дүгнэх журамд тусган оруулах

5. Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн ажлыг хилийн зөрчил илрүүлсэнтэй адил хэмжээнд тооцож үнэлж байх хэрэгтэй бөгөөд ингэснээр хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг, "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт нь улам боловсронгуй болно гэж үзэж байна.

***Н.Очирдорж*** *-Хууль сахиулах удирдлагын академийн*
*821 дүгээр дамжаан суралцагч дэд хурандаа*

## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАХ ОПЕРАТИВ УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Улсын хил хамгаалалтын урлагийг хөгжүүлэх асуудал нь нийгмийн хөгжил, эрхзүйн орчны шаардлага бөгөөд цаад утгаараа бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэх үндэс хил хамгаалах байгууллагын удирдлагын хэмжээнд анхаарах асуудал болоод байна.*

***Түлхүүр үг:*** *Улсын хил хамгаалалт, хил хамгаалах урлаг. хил хамгаалах оператив урлаг.*

Хил судлалын шинжлэх ухаан, хил хамгаалах урлагийн онолын салшгүй, бүрэлдэхүүн хэсэг нь “Хилийн цэргийн оперативын урлаг" юм.

***Хилийн цэргийн оперативын урлаг гэдэг нь*** улсын хил дээр буюу хилийн орон зайд Монгол Улсын улс төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хилийн цэргийн оперативын бүлгүүдийн (хилийн төлөөлөгчийн газрын) ажиллагааг бэлтгэх, явуулахтай холбогдсон онол, практикийн цогцолбор мөн[1].

Шинэчилэн батлагдсан “Хилийн тухай хууль”-д

1. Хилийн нөхцөл байдал, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт гэнэ.

[1] *Н.Наранжамц.* Хилийн операци. - УБ., 1998. 29 дэх тал.